



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ
БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА-Д

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14280 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41. Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: somong@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.05.26 № 03/АЗЖТ
танай _____ -ны № _____ -т

Handwritten signature

Мэдээлэл хүргүүлэх тухай

Handwritten signature and date: 2023.05.26

Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/31 тоот "Маягт батлах тухай" тушаалаар нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын болон бусад холбогдох бүртгэлийн маягтыг шинэчлэн, давхар ажил эрхлэлт, бэлэг, үйлчилгээний бүртгэлийн маягтыг шинээр батлаад байна.

Уг тушаалыг 2023 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөх тул өөрийн байгууллага болон харьяа салбар, байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана уу. Үүнд:

- Хавсралт 1 "Мэдүүлэг гаргагчийн ... оны хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт";
- Хавсралт 2 "Мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт";
- Хавсралт 3 "Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт";
- Хавсралт 4 "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэлийн маягт";
- Хавсралт 5 "Оффшор бүсэд эзэмшиж байгаа банкны данс, өмчилж байгаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, байгуулсан хуулийн этгээдийн бүртгэлийн маягт";
- Хавсралт 6 "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлсэн тухай бүртгэлийн маягт";
- Хавсралт 7 "Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд гаргасан мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөлд гаргасан тайлбар, шийдвэрлэлтийн бүртгэлийн маягт";
- Хавсралт 8 "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтны бүртгэлийн маягт";
- Хавсралт 9 "Давхар ажил эрхлэлтийн бүртгэлийн маягт";
- Хавсралт 10 "Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан бэлэг, үйлчилгээ, түүнийг авсныг мэдэгдсэн тухай бүртгэлийн маягт";

Жич: Тушаалыг тус газрын албан ёсны хуудсанд <https://iaac.mn/post/105048> байршуулсан тул файлаар татан авч, танилцах боломжтой.

Хавсралт: 6 хуудастай

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Handwritten signature and stamp